



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 21365

Хэрлэн сум


“Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай”

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Зүүн бүсийн түншлэл-Хэнтий 2023” үзэсгэлэн худалдаа зохион байгуулах Засаг даргын 2023 оны А/542 дугаар захирамжаар өгөгдсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллаагүй, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 16 дугаар хуралдааны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлт хангалтгүй, тайлан мэдээг цаг хугацаанд нь ирүүлээгүй зөрчил гаргасан тул Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргад сонсох ажиллагаа явуулах итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Э.Мөнх-Эрдэнэ, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн Г.Ариунчимэг нарыг томилсугай.

2.Сонсох ажиллагааг Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу явуулж гарсан саналыг 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн дотор танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Э.Мөнх-Эрдэнэ, хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн Г.Ариунчимэг нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ